БАТЛАВ. АҮЭБЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА С.ЖАВХЛАНБААТАР

Монголын ОҮИТБС-ын 2024 оны буюу 19 дүгээр нэгтгэл тайлан гаргах ажлын даалгавар

2025 оны 2 дугаар сарын 12=-ний өдөр Улаанбаатар хот

1. **Оршил**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) нь газрын тос, хий, уул уурхайн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжин ажилладаг Дэлхийн стандарт юм. ОҮИТБС-ын хэрэгжилт нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Үүнд:

- **Ил тод байдал**: Эрчим хүч, олборлох салбарын компаниуд нь өөрийн үйл ажиллагааны тухай мэдээллээ Засгийн газарт төлсөн төлбөрийн хамт ил тод болгоно. Засгийн газар мөн өөрийн зүгээс уг салбараас хүлээн авсан орлого болон холбогдох бусад мэдээллийг ил тод болгоно. Эдгээр санхүүгийн тоо баримтыг жил бүр олборлох салбарын нөхцөл байдал болон бусад мэдээллийн хамт ОҮИТБС-ын стандартад нийцүүлэн хэвлэн нийтэлнэ.
- **Хариуцлагатай байдал**: Засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэх олон талт оролцогч ажлын хэсгээс хянан үзсэн ил тод болгож буй үйл ажиллагаа нь олборлох салбарын хайгуул, олборлох төвшин, нэмүү өртөгийн салаа бүрийг хамарч, салбарын удирдлагын талаар олон нийтийн хэлэлцүүлгийг идэвхжүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. Ажлын хэсэг нь энэ үйл ажиллагааг хянаж, дүгнэлтүүдийг танилцуулж, ОҮИТБС-ын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг өргөн хүрээнд ил тод болгох арга ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2. **ОҮИТБС-ын Стандартын дагуу ил тод болгох шаардлагууд**

ОҮИТБС-ын хүрээнд ил тод болгох асуудлууд:

- **Хууль эрх зүйн тогтолцоо** (Шаардлага 2.1, 2.4 болон 6.4)
- **Олборлох салбарын тойм** (Шаардлага 3.1 болон 6.3)
- **Тусгай зөвшөөрөл олголт, гэрээ байгуулах** (Шаардлага 2.2, 2.3 болон 2.4)
- **Эцсийн өмчлөл** (Шаардлага 2.5)
- **Төрийн оролцоо** (Шаардлага 2.6, 4.2, 4.5 болон 6.2)
- **Орлого төвлөрүүлэлт** (Шаардлага 4.1 ээс 4.8 болон 4.10)
- **Орлогын удирдлага** (Шаардлага 5.1 ба 5.3)
- **Үйлдвэрлэл, экспорт болон утаа ялгаруулалт (Шаардлага** 3.2, 3.3 болон 3.4)
- **Орон нутаг оруулсан хувь нэмэр** (Шаардлага 4.6, 5.2 ба 6.1)
- **Байгаль орчин болон нийгмийн нөлөөлөл** (Шаардлага 6.4)

- Өгөгдөл мэдээллийн чанарын шаардлага (Шаардлага 4.9) болон боломжтой газраа задаргаатай байх (Шаардлага 4.7).

Системтэй ил тод байдал

ОҮИТБС-ын хүрээнд хүлээгдэж буй нэгэн шаардлага бол системтэй ил тод байдал юм. "Системтэй ил тод байдал" гэдэг нь Засгийн газар, Компани зэрэг албан ёсны байгууллага өөрийн, эсхүл төвлөрсөн цахим сайт, эсхүл хэвлэмэл байдлаар олон нийтэд, тогтмол, хугацаа хоцроохгүйгээр, хүртээмжтэй байдлаар өөрийн албан сувгаараа мэдээллээ ил тод болгохыг хэлнэ. Өгөгдөл мэдээлэл байвал хариуцсан хуулийн этгээд нь /эх сурвалж/ гэдгээр хэвлэн нийтлүүлнэ.

ОҮИТБС-ын хүрээнд олон нийтэд ил болгон байршуулсан мэдээлэл, эсхүл тайлагнах зорилгоор төвлөрүүлсэн өгөгдөл мэдээллийн эх сурвалжийн байршлыг ил болговол шаардлагыг хангасан гэж үзэх боломжтой. Энэ тохиолдолд ОҮИТБС-ын тайлан нь нөхцөл байдлын талаархи нэмэлт мэдээлэл, системтэй ил тод байдлын эх сурвалжуудыг нэгтгэн, мэдээллийн чанарын дутуу, эсхүл итгэл төрүүлэхүйц эсэхэд үнэлгээ агуулсан байна.

Өгөгдөл мэдээллийн цаг хугацааны хүчин зүйл

ОҮИТБС-ын шаардлага 4.8- д орлогын эсхүл санхүүгийн өгөгдөл мэдээллийн хамрах хугацаа нь санхүүгийн бүтэн 2 жилээс хэтрэхгүй байхаар заасан байна. Жишээлбэл, 2024 оны санхүүгийн жилийн тайланг хамгийн их хоцрохдоо 2026 оны 12 дугаар сарын 31-нээр тайлагнаж, ил тод хэвлэсэн байна гэсэн үг юм. Нөгөө талаас, улс орнууд энэ хугацаанаас аль болох өмнө хэвлэн нийтэлсэн байх нь зүйтэй гэсэн хэрэгтэй гэж үздэг байна. Олон талт ажлын хэсэг нь ОҮИТБС-ын тайлангаар нэг болон түүнээс олон тооны санхүүгийн жилийг хамруулах боломжтой, ингэснээр ОҮИТБС-ын нэгтгэл тайланг боловсруулах **Хуулийн этгээд-**ийг сонгон шалгаруулахтай холбогдсон бэрхшээлийг шийдэж болох юм.

Монгол Улсын ОҮИТБС-ыг хэрэгжүүлж байгаа талаар товч танилцуулга

Монгол Улсын Засгийн газраас ОҮИТБС-д нэгдэх шийдвэрээ 2006 онд гарган, түүнээс хойш тасралтгүй хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийг Засгийн газар, уул уурхайн компани, иргэний нийгмийн төлөөллөөс 2006 онд байгуулж, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэсэн байна. Олон талт оролцогчдын ажлын хэсэг нь ажлын албаны туслалцаатайгаар ОҮИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулан жил бүр Үндэсний зөвлөлөөр батлуулж, уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл явуулж байгаа болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компаниудаас бүх шатны (улс, аймаг, дүүрэг, сум) төсөвт төлсөн төлбөр, Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогын тайланг талаас гаргуулж байна.

Эдгээр байгууллагуудаас гаргах ОҮИТБС-ын тайлангийн маягтуудыг анх 2007 онд батлаж, 2008, 2011, 2012, 2015 оны сүүлчээр шинэчлэн, 2014 оноос эхлэн цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Мөн 2020, 2022 онд компаниуд болон төрийн байгууллагуудын тайлагнах маягтуудыг ОҮИТБС-ын 2019 оны стандартад нийцүүлэн шинэчлэн батлан, цахимаар тайлагнаж байна.

Энэ хугацаанд Монгол Улс нийт 18 тайлан гарган хэвлэн нийтлүүлж, 2025 онд 19 дүгээр тайлангаа бэлтгэн гаргана. Монгол Улсын 2006 оны нэгдсэн буюу анхны тайланг Австралийн "Крейн Уайт энд Ассоушиэтс" хэмээх аудиторын компани, 2007 оны тайланг

Монгол, Малайзын “Эрнст Янг” аудитын компаниудын консорциум боловсруулсан бол 2008, 2009, 2010, 2011, 2013, 2015, 2017 онуудын тайланг Их Британийн “Харт Нойрс” лдт, Монгол Улсын “Улаанбаатар аудит корпорац”-ын консорциум гаргасан байна.

2012 оны тайланг Их Британийн “Мүүр Стефенс”, Монгол Улсын “Далайван аудит“ компаниудын консорциум, 2014, 2016 он тайланг “Кей Пи Эм Жи Монгол”, “Кей Пи Эм Жи Франц” аудит компаниудын консорциум, Монгол-Тунисийн “БДО” аудитын компаниудын консорциум 2018 оны тайланг гаргасан байна.

2019, 2020 оны тайлангуудыг Монгол Улсын “Грант Торнтон” аудит ХХК, 2021 оны тайланг Монгол Улсын СИКА ХХК, Гроуф файненс аудит ХХК-ийн түншлэл ОҮИТБС-ын Удирдах Хорооны 2020 оны зөвлөмжөөр Ковид-19 өвчний цар тахлаас улбаалан уян хатан хэлбэрээр гаргасан байна. 2022 болон 2023 оны тайланг Монгол Улсын СИКА ХХК, Гроуф файненс аудит ХХК-ийн түншлэл уламжлалт хэлбэрээр тус тус боловсруулсан байна.Тайлангуудын товч мэдээллийг харуулав.Үүнд:

Он	Тайлан гаргасан компа-ни	Засгийн газрын харьяа байгууллагуудаас гаргасан тайланд орсон компани	Улсын нэгтгэл тайланд орсон компаниуд	Нэгтгэгдсэн дүн, тэрбум төгрөг	Улсын төсвийн урсгал орлогод эзлэх хувь	Тайлбар-лагдаагүй зөрүү, төгрөг
2006	64	137	25	492	36	4 тэрбум
2007	102	184	38	745	40	775 сая
2008	115	184	46	686	32	420 сая
2009	129	363	101	737	37 хувь	58 сая
2010	274	477	150	1,275	48 хувь	356 мянга
2011	301	518	200	2,150	54 хувь	75 сая
2012	1531	1829	200	1,594	33 хувь	360 сая
2013	1197	1617	250	1,576	27 хувь	37 сая
2014	992	1570	236	1,579	25 хувь	581 сая
2015	747	1920	202	1,393	30 хувь	112 сая
2016	1227	2086	213	1,073	19 хувь	74 сая
2017	1489	2091	230	2,358	28 хувь	236 сая
2018	1490	1986	202	2,816	30,5 [1]	279 сая
2019	1472	2423	171	3,653.8	33,1 [2]	25 сая
2020[3]	1419	1655	60	3,211.79	30,75[4]	527 сая
2021[5]	1492	1700	63	3,252.57	21 [6]	19 сая
2022	1172	1702	104	4,687.86	27,5[i]	7,106,6 сая
2023	1096	2093	125	8,439,14	34,7[7]	133,371 тэрбум

[1] 2018 оны улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,234.9 тэрбум төгрөг байв.

[2] 2019 оны улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 10,801.6 тэрбум төгрөг байв. https://mof.gov.mn/article/entry/NEWS-2020-03-25

[3] Уян хатан

[4] https://mof.gov.mn/data_grid/total-budget- Улсын төсвийн орлого 10,444.20 тэрбум төг байв

[5] Уян хатан

[6] https://www.parliament.mn/mn/16975/ Улсын төсвийн тодотголоор орлого 15,5 их наяд тг.Нягтлан бодох бүртгэлтэй 83 компанийн тайланг нэгтгэсэн байна.

[7] https://mcd.gov.mn/post/152208 Улсын төсвийн урьдчилсан гүйцэтгэл 24,3 их наяд тог байв.

Монголын ОҮИТБС-ын Үндэсний Зөвлөлөөс 2025 оны Ажлын төлөвлөгөөгөө баталж, зорилтуудаа "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх, ОҮИТБС-ын шинэ стандартын шаардлагуудыг ханган хэрэгжүүлэх" гэж томьёолсон байна. https://www.eitimongolia.mn/p/10.

3. Даалгаврын зорилго

Монгол Улсын Засгийн газар, ОҮИТБС-ын Олон талт ажлын хэсгийн нэрийн өмнөөс Ажлын алба нь ОҮИТБС-ын 2023 оны стандартын дагуу ОҮИТБС-ын Нэгтгэл тайлан боловсруулах үйлчилгээ үзүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, чадвартай, итгэл даахуйц **Хуулийн этгээд**-ийг хайж байгаа болно.

Даалгаврын зорилго нь ОҮИТБС-ын стандартын дагуу ил тод байдлыг хангах, ил болсон мэдээллийг иж бүрэн хамруулж, үнэн бодит байдалд үнэлгээ өгөх, Засгийн газрын мэдээллийн систем, байгалийн баялгийн засаглалын удирдлагыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хуулийн этгээд-ээс хийгдэх ажлууд:

- ОТАХ-ийн шийдвэр гаргах үйл явцад зориулж Монгол Улсын 2024 оны нэгтгэл тайлангийн цар хүрээг тодорхойлох судалгаа хийж, танилцуулна;
- ОҮИТБС-ын стандарт болон энэ ажлын даалгаврын 4-т заасны дагуу Монгол Улсын ОҮИТБС-ын 2024 оны нэгтгэл тайланг боловсруулах, 100-аас доошгүй тооны компаниудын тайланг тулган баталгаажуулалтад хамруулж, орлогын бус мэдээллийг ОҮИТБС-ын 2023 оны стандартын дагуу боловсруулж, тайланд нэгтгэнэ;
- Нэгтгэл тайланд хуучин нэрээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/123 тоот тушаалаар баталсан ОҮИТБС-ын тайлангийн маягт, орлогын урсгалыг ашиглана.
- Дээрх тушаалаар батлагдсан маягтыг тайлан гаргасан компаниудын бөглөсөн байдлын судалгааг гаргаж, хавсаргахын хамт бөглөсөн байдалд үнэлгээ дүгнэлт өгнө.
- Системтэй ил тод болгоогүй орлогын мэдээллийг цуглуулах, мэдээллийн үнэн зөв байдал, хугацаа болон бүрэн бүтэн эсхийг 4.7, 4.8, 4.9 шаардлагуудад заасны дагуу үнэлж, дүгнэлт гаргана;
- Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын хувьд олборлох салбарын засаглалыг сайжруулах, олон улсын жишигт хүрэхүйц хэмжээнд салбарыг удирдахад анхаарах бүтээлч дүгнэлт, хэрэгжихүйц зөвлөмжийг гаргана;
- Монгол Улсын ОҮИТБС-ын 2018-2023 оны нэгтгэл тайлангуудаар өгсөн зөвлөмжүүдийн биелэлтэд үнэлгээ өгөх, шийдвэрлэхэд нь тодорхой дүгнэлт, зөвлөмж гаргана;
- Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны олон улсын баталгаажуулалтын зөвлөмжүүдийн биелэлтэд үнэлгээ өгөх, шийдвэрлэхэд нь тодорхой дүгнэлт, зөвлөмж гаргана;
- Энэхүү Ажлын даалгаврын хүрээнд нэгтгэл оролцож байгаа Засгийн газрын байгууллагууд, компаниудаас "Системтэйгээр ил тод болж буй мэдээлэл"- ийн эх сурвалжуудад задлан шинжилгээ хийх, тэдгээр нь ОҮИТБС-ын стандартын

шаардлагыг хангаж байгаа эсхийг тодорхойлох, үнэлгээ өгөх, засч сайжруулахад[8] нь тодорхой дүгнэлт, зөвлөмж гаргана;

- Олборлох үйлдвэрлэлийн засаглалд ил тод байдал хэрэгжүүлэхдээ ямар нэг гажуудал, дутагдал байгаа эсхийг үнэлж, байгаа бол баримтжуулж, Ажлын хэсэгт танилцуулна;
- Ил тод болж буй мэдээллүүд нь Монгол Улсын нөхцөл байдалд үнэлгээ өгөхөд нийцэж байгаа эсэх талаар үнэлгээ өгч, зөвлөмж гаргана;
- ОҮИТБС-ын ОУНБГ- аас баталсан маягтын дагуу 2024 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн өгөдлийн хураангуй "Data summary" буюу "Өгөдлийн хураангуй"- г боловсруулж цахимаар ОҮИТБС-ын ОУНБГ-т хүргүүлнэ.

4. ОҮИТБС-ын тайлан боловсруулах явц

ОҮИТБС-ын тайланг боловсруулах ажил дараах 5 шатнаас бүрдэнэ (зураг 1-ийг харна уу).

1. Хамрах хүрээ
2. Мэдээлэл цуглуулах, эхний задлан шинжилгээ
3. Мэдээллийн чанарын баталгаа
4. Ажлын хэсэгт зөрүү, дутуу байдлыг танилцуулах, задлан шинжлэх
5. ОҮИТБС-ын тайлагналын үр нөлөө

Зураг 1 – ОҮИТБС-ын тайлан боловсруулах явц



[8] "Системтэй ил тод болгох" гэдгийг энэ даалгаврын 2-р хуудаст "Засгийн газар, Компани зэрэг албан ёсны байгууллага өөрийн, эсхүл төвлөрсөн цахим сайт, эсхүл хэвлэмэл байдлаар олон нийтэд, тогтмол, хугацаа хоцроохгүйгээр, хүртээмжтэй байдлаар өөрийн албан сувгаараа мэдээллээ ил тод болгохыг хэлнэ" гэснийг ойлгоно.

Эдгээр үе шатууд нь зарим тохиолдолд давхардах эсхүл үе шат хооронд давтагдаж болно.

Үе шат 1: Хамрах хүрээний задлан шинжилгээ

Зорилт: Энэ үе шатанд **Хуулийн этгээд** нь ОҮИТБС-ын стандартын шаардлагууд, Ажлын хэсгээс дэвшүүлсэн зорилтуудыг хангахад ОҮИТБС-ын тайланд хамруулах хүрээний асуудлуудыг задлан шинжилж тодорхойлж өгөх юм. Холбогдох судалгаа нь ОҮИТБС-ын тайланг хугацаандаа нийцсэн, иж бүрэн, үнэн зөв мэдээлэлтэй байхыг суурь болно.

Үүнд Засгийн газрын орлого, орлогын бус мэдээллийг задлан шинжлэх, хамрах санхүүгийн жилийг тодорхойлох ажил хийнэ.

Судалгаа хийх явцад дараах асуудлуудыг нягтлан үзэж холбогдох тайланд хамруулна. Үүнд:

- Олборлох салбарт болсон сүүлийн үеийн өөрчлөлтүүд, Засаглалтай холбогдсон өргөн хүрээний асуудлууд;
- ОҮИТБС-ын өмнөх тайлангууд, нарийвчилсан судалгаа, Баталгаажуулалтын зөвлөмжүүд.

Хуулийн этгээд нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

1.1 Холбогдох суурь мэдээллийн задлан шинжилгээ хийнэ: Засаглалын зохицуулалт, татварын бодлого, системтэй ил тод байдлын судалгаа, хамрах хүрээний урьдчилсан судалгаа, Засгийн газар, компаниудын ил тод тайлагнал, өмнөх ОҮИТБС-ын тайлангууд болон Баталгаажуулалтын дүгнэлт, зөвлөмжүүдийг хянан үзнэ. (Хавсралт А холбогдох баримт бичгүүдийн жагсаалт.)

Анхаарах асуудал: Ажлын хэсэгтэй зөвлөлдсөний үндсэн дээр ОҮИТБС-ын стандартаар "заавал биелүүлэхийг шаардаагүй" зарим асуудлыг тайландаа хамруулж болно. Үүнд, 3.4-р шаардлагаар шаардсан хүлэмжийн хийн ялгаруулалт, 4.10-р шаардлагаар шаардсан төслийн зардал.

1.2 Ажлын хэсэгт засаглалын гол асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ: Мөрдөж буй жилийн ажлын төлөвлөгөөн дээр үндэслэн гол оролцогч талуудтай зөвлөлдөх, чухал гэсэн асуудлууд, тэдний эрэмбийг тодорхойлох, тайланд хамруулах, холбогдох мэдээлэл, баримтыг оруулах, тэгсэнээр ОҮИТБС-аас тавьсан шаардлагуудыг хангахад анхаарна.

1.3 Хариуцах хуулийн этгээдүүдийг тодорхойлж өгнө: Засгийн газрын аль байгууллага, компани нь шаардлагатай мэдээллийг гаргах, цуглуулах, хадгалах үүрэгтэйг тодорхойлно.

1.4 Мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй эсхийг үнэлнэ: Засгийн газрын байгууллага, компаниудаас олон нийтэд ил тод болгосон мэдээллийг хянах, тэдгээрийн хэлбэр, агуулга, мөн давтамж, цаашид баяжуулах боломжуудыг нягтлана.

1.5 Мэдээллийн иж бүрдэл, задаргааны түвшинг үнэлнэ: ОҮИТБС-ын стандартын дагуу ил болгосон мэдээллийн цаг хугацаа, иж бүрдэл, задаргааны түвшинг үнэлнэ. Хэрэв нэг мэдээллээр олон тооны ил тодын эх сурвалж байвал тэдгээр нь хоорондоо зөрүүтэй, эсхүл ялгаатай эсхийг үнэлнэ.

1.6 **Мэдээллийн чанарыг баталгаажуулах механизмыг тодорхой болгоно:** Ажлын хэсэгтэй зөвлөлдөн ил тод болгосон мэдээлэл нь хүлээн авч болохуйц чанарын ямар стандарт хангасан байхыг аудитын дүрэм журмыг оруулан тодорхой болгоно.

1.7 **<u>Хуулийн этгээд</u> нь орлогын мэдээллийн хувьд дараах ажлыг гүйцэтгэх ёстой. Үүнд:**

- **1.7.1** Тайлант санхүүгийн жилд Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан бүх төлбөрийн жагсаалт;
- **1.7.2** Хүчин төгөлдөр зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, эрх, ашигт малтмал олборлох гэрээний мэдээлэл;
- **1.7.3** Хүчин төгөлдөр зөвшөөрлийн төлбөрийг хийсэн компаниудын төлбөрүүд;
- **1.7.4** Ажлын хэсэгтэй зөвлөлдөн олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан орлогуудын материаллаг босгыг тогтоож, холбогдох хувилбаруудын баримтжуулалтыг оруулна;
- **1.7.5** Хүчин төгөлдөр бус зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, эрх, олборлох гэрээгүй компаниудаас хүлээн авсан материаллаг төлбөрийг хянах, тайланд оруулах эсхийг үнэлнэ;
- **1.7.6** Ажлын хэсэгтэй материаллаг босгыг зөвлөлдсөний үндсэн дээр бүх материаллаг компани, төрийн байгууллагуудыг хамруулна;
- **1.7.7** Задаргааны түвшиний тухай 4.7 шаардлага, мэдээллийн чанарын тухай 4.9 шаардлагуудад нийцүүлэн мэдээллийг ил тод болгоно.

Үе шат 2: Мэдээлэл цуглуулах ба эхний задлан дүн шинжилгээ

Зорилго: Энэ үе шатны зорилго нь ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн иж бүрдэлийг хангах талаар задлан шинжилгээ явуулахад оршиж байна. ОҮИТБС-ын стандартаар шаардсан мэдээллүүд хангалттай ил тод болоогүй байх талтай учир мэдээлэл цуглуулах явцад ямар орлого болон орлогын бус мэдээллүүд дутуу дулимаг байгааг тодорхойлж өгнө.

Ажлын хэсгээс баталсан хамрах хүрээнд **<u>Хуулийн этгээд</u>** нь энэ үе шатанд мэдээлэл цуглуулна. Ажлын хэсэг, албанаас тайлагнасан байгууллагуудтай холбоо барих мэдээллийг өгөхөөс гадна тэдгээр байгууллагуудын оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх ёстой.

<u>Хуулийн этгээд нь</u> дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

2.1 **Ил тод болсон материалуудыг нэгтгэх:** Засгийн газрын байгууллагууд, компаниудаас ил тод болгосон тайланг шалгах, нэгтгэх (системтэйгээр ил тод болсон холбогдох материалыг хамруулна) бөгөөд ОҮИТБС-ын тайланд аль болох давхардуулахгүй байна.

2.2 **Нэгтгэл тайлангийн маягтыг боловсруулна:** Нэгтгэл тайланд оруулах мэдээлэл, өгөгдлийн маягтыг боловсруулж, Ажлын хэсэгт танилцуулж саналыг авч батлуулсан байна. **Анхаарах асуудал:** Орлогын бус мэдээллийн маягт нь мэдээллийг улам тодруулах, үнэн зөвийг хангуулахад дэмжлэг болох ёстой тул Ажлын хэсгээс түүнийг хянан үзсэн байна.

2.3 **Танилцах уулзалт зохион байгуулах:** Тайлагнах байгууллагуудад маягтаа танилцуулж, ойлгуулах талаар уулзалт сургалт зохион байгуулна.

2.4 **Бөглөсөн маягт, холбогдох материалуудыг цуглуулах:** Тайлан гаргасан оролцогч байгууллагуудаас бөглөсөн маягт, дагалдах баримт бичгүүдийг цуглуулна.

2.5 **Эхний зөрүү эсхүл дутууг тодорхойлох:** ОҮИТБС-ын тайлагналын зөрүү, дутуу эсхүл ямар бэрхшээл байгааг олж тогтоох, шийдвэрлэх ямар арга, зөвлөмж байж болохыг тодорхойлно.

2.6 **Мэдээллийн иж бүрдэлийг задлан шинжлэх:** Цуглуулсан мэдээллүүд ОҮИТБС-ын стандартын бүх шаардлагуудын иж бүрдлийг хангаж байгаа эсхийг хянан үзнэ. Мөн Баталгаажуулалтаас өгсөн зөвлөмжүүдтэй хир нийцэж байгааг давхар хянана.

2.7 **Мэдээллийн зөрүү эсхүл дутууг тодруулах:** Шаардлагатай бол тайлагнасан байгууллагатай шууд холбоо барьж ирүүлсэн мэдээллийн зөрүү, эсхүл дутууг тодруулна.

Үе шат 3: Мэдээллийн чанарын баталгаа

Зорилт: Энэ үе шатны зорилт нь ил тод болгосон мэдээллийг ОҮИТБС-ын стандартын 4.9b шаардлагын дагуу олон улсын аудитын стандарт дээр суурилсан хараат бус, нэр хүндтэй аудитаар хянуулах явдал болно. Ажлын хэсэг нь мэдээллийн чанарын баталгаажуулалтын стандарт болох аудитын тулган баталгаажуулалт, эрсдэлд суурилсан аргачлал гэсэн 2 стандартын аль нэгийг сонгох боломжтой байдаг. Үүнээс өөр аргыг сонгох тохиолдолд ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс урьдчилан зөвшөөрөл авсан байна.

Аудитын тулган баталгаажуулалт

Тулган баталгаажуулалтын үеэр **Хуулийн этгээд** нь Засгийн газрын байгууллагууд, компаниудаас ил тод болгосон бүх материаллаг орлого, төлбөрүүдийн санхүүгийн мэдээллийг тулгана. Энэ ажлын зорилго нь эдгээр мэдээллүүдийг тулгах явцад үүссэн зөрүүг тохируулан шийдвэрлэх, олборлох салбарын орлогын мэдээллийн иж бүрдэл, итгэж болохуйц байдлыг баталгаажуулна. Энэ нь 100 хувийн аудит биш боловч аудитын "ISRS 4400" хэмээх баталгаажуулалтын олон улсын нэгэн аргачлал юм.

Хэрэв материаллаг орлого төлбөр бүхий тайлагнагч байгууллага, хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нь тайлант хугацаанд аудитлагдсан бол тулган баталгаажуулалтад хамрагдаж байгаа материаллаг орлого төлбөр бүхий компани, Засгийн газрын байгууллагууд нь удирдлагын хариуцлагын бичгийг ирүүлнэ. Тэр бичиг нь ОҮИТБС-ын тайланд орсон мэдээллүүд нь тухайн тайлагнасан байгууллагын аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байгаа тухай нотолгоо агуулсан байна.

Тийм биш бол, материаллаг төлбөр бүхий тайлагнасан байгууллагууд, компани нь тайлант хугацаанд санхүүгийн тайлангаа аудитлаагүй бол **Хуулийн этгээд** нь ОҮИТБС-ын тайлангаа компанийг хөндлөнгийн аудитын компаниар, Засгийн газрын байгууллагыг төрийн дээд шатныхаа аудитын байгууллагаар баталгаажуулж өгөхийг хүснэ.

Хуулийн этгээд нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1 **Орлогын аудитыг үнэлэх:** Засгийн газар, компанийн тайлангийн мэдээллийг ОҮИТБС-ын стандартын Шаардлага 4 болон олон улсын аудитын стандартын дагуу хараат бус эрх бүхий аудитаар баталгаажуулна.

3.2 **Өгөгдөл мэдээллийн чанарын талаар авах арга хэмжээ зөвлөмж болгох:** Хэрэв үнэлгээний явцад өгөгдөл мэдээллийн чанарын талаар тодорхой зовнил гарсан бол тэдгээрийг шийдвэрлэх, баталгаажуулалтыг сайжруулах арга ажиллагааны талаар санал бэлтгэнэ.

3.3 **Тайлагнах маягтын загвар:** Тайлагнагч нарт хүргүүлэх тайлангийн маягтыг боловсруулахдаа өгөгдлийн мэдээллийн чанарын тухай асуултыг оруулах, тэгэснээр зөрүүтэй байдлыг оновчтой тогтоох, мөшгих түвшинг нарийвчлах боломжтой болно.

3.4 **Хэрэглэсэн аудитын журмыг хянах:** ОҮИТБС-ын тайлангаа гаргасан Компани, Засгийн газрын байгууллагуудын аудит, баталгаажуулалтын журмыг хянаж, үзнэ. Үүнд хамаарах хууль, журам болон төлөвлөж буй шинэчлэлтэй танилцахын хамт олон улсын стандартад нийцэж байгааг хангах асуудал хамаарагдана. ОҮИТБС-ын нэгтгэл тайланд энэ талын ажиглалт дүгнэлтийг оруулах ёстой.

3.5 **Стандартын журмуудыг хэрэглэхийг санал болгох:** Аудит, баталгаажуулалтын журмыг хянаж үзсний үндсэн дээр ОҮИТБС-ын тайланг бэлтгэгч **Хуулийн этгээд** нь ОҮИТБС-ын нэгтгэл тайланг итгэл үнэмшил төрүүлэхүйц, иж бүрэн байлгах үүднээс мэргэжлийн дүгнэлт, олон улсын стандартыг ашиглана. Мөрдөгдөж байгаа хяналт, аудитын тогтолцоо нь ямар түвшинд олон улсын аудитын стандартуудад нийцэж байгаа талаар мэргэжлийн дүгнэлтийг гаргах ёстой.

3.6 **Ил тод болсон мэдээллийн иж бүрдэлд үнэлгээ өгөх:** Тайлан гаргасан этгээдүүдийн мэдээлэл нь тохиролцсон цар хүрээнд нийцэж байгаа эсхийг үнэлэх, дутуу зүйл байгаа эсхийг, хэрэв дутуу бол мэдээллийн чанарт ямар нөлөө үзүүлэхийг тогтооно.

3.7 **Зөрүүтэй байдлыг тогтоох:** Санхүүгийн аюулгүй байдлын зүгээс тодорхой болсон зөрүү нь зөвшөөрөгдсөн алдаанаас давсан эсэх, эсхүл тухайн эрсдэлийг тодорхойлж Ажлын хэсэгт танилцуулна.

3.8 **Орлогын бус мэдээллийн ил тод байдалд чанарын баталгааны талаар зөвөлгөө өгөх:** ОҮИТБС-ын стандартын Шаардлага 2,3,5,6-д нийцүүлэн орлогын бус мэдээллийг ил тод болгохдоо чанарын баталгааг хангах чиглэлийг Ажлын хэсэгт өгнө.

3.9 **Зөвлөмжүүд боловсруулах:** Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал, ил тод байдлын системийг сайжруулах талаар хэрэгжихүйц зөвлөмжүүдийг боловсруулж санал болгоно.

Үе шат 4: Ажлын хэсэгт зөрүүтэй байдлыг танилцуулах, задлан шинжилгээ

Зорилт: Энэ үе шатны зорилт нь тайлант хугацаанд засаглалын гол асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд Ажлын хэсгээс өгөгдөл мэдээллийг задлан шинжилгээ явуулахад нь мэдээллээр хангахад оршино.

Хуулийн этгээд нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

4.1 **Мэдээллийг ил тод болгоход гарсан эхний ажиглалтуудаа танилцуулах:** ОҮИТБС-ын стандарт, Ажлын хэсгийн зорилтуудын эрэмбэ дараалалд үндэслэн иж бүрэн ил тод болгоход бий болсон гол ажиглалт, учирж байгаа хуулийн болон практикийн бэрхшээлүүдийг Засгийн газраас гаргасан тэдгээрийг арилгах төлөвлөгөө, хэрэгжүүлэх хугацааны хамт танилцуулах бөгөөд танилцуулга нь дараах асуудлуудыг хамарч болно. Үүнд:

4.1.1 **Материаллаг зөрүүтэй байдал:** Тусгай зөвшөөрөл шилжүүлэх, олгох тухай хууль, зохицуулалтын тогтолцооноос ихээхэн зөрсөн нөхцөл байдал, холбогдох үнэлгээний аргачлалын тайлбар.

4.1.2 **Тусгай зөвшөөрлийн журам:** Тусгай зөвшөөрлийн журмын үр дүн, үр өгөөжтэй байдлын талаар санал шүүмж; гэрээ, эсхүл тусгай зөвшөөрлийг

шинэчлэх, түдгэлзүүлэх, цуцлах тухай журмын танилцуулга, бодит практик, үндэслэлүүд; мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн өмчлөлийн өөрчлөлтийн тухай мэдээлэл.

4.1.3 Бүртгэл ба кадастр: Хэрэв тусгай зөвшөөрлийн бүртгэл, эсхүл кадастр дахь зарим мэдээлэл дутуу, эсхүл байхгүй бол ил тод болгох талаар зөвлөмж өгөх, эдгээр системүүдийг сайжруулах талаар үйл ажиллагаа явагдсан бол баримт нотолгоог оруулна.

4.1.4 Гэрээ ба тусгай зөвшөөрөл: Гэрээ, тусгай зөвшөөрлийг ил тод болгох тухай хууль, Засгийн газрын бодлогын шаардлагуудаас зөрсөн зүйл байвал олж тогтооно.

4.1.5 Эцсийн өмчлөл: Эцсийн өмчлөлийн тайлагналд томоохон дутуу, эсхүл дулимаг зүйл байвал тайланд оруулах, мэдээллээ бүрэн гаргаагүй хуулийн этгээдийг мөн хамруулна.

4.1.6 Орлогын мэдээллийн чанарын баталгаа: Орлого тулган баталгаажуулах явцад гарсан томоохон зөрүүг тайлбарлана.

4.1.7 Төрд ноогдох хувийг борлуулах: Төрд ноогдох хувийг борлуулах компанийг сонгох, холбогдох хувийг борлуулах гэрээг зохицуулж байгаа хууль зохицуулалтын тогтолцоонд материаллаг зөрүү гарсан эсхийг анхааруулна.

4.1.8 Орлого шилжүүлэх: Төвөөс орон нутаг руу илгээх шилжүүлгийн төлөвлөлт, илгээлтийн хооронд зөрүү байсан эсхийг мэдээлэх, холбогдох орлого хуваарилах томьёо танилцуулах, ямар нэг зөрүү гарсан бол Засгийн газрын зүгээс тайлбар гаргуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

4.1.9 Нийгэм, байгаль орчны үүрэг амлалт: Нийгэм, байгаль орчны зарцуулалт, эсхүл төлбөрийн талаар авсан хууль зүйн эсхүл гэрээний үүрэг амлалт практик дээр биелсэн эсэх талаар үнэлгээ хийнэ.

4.1.10 Зөрүү болон дутуу байдал: Ил тод болсон мэдээллүүд нь зөрүүтэй, дутуу, нийцэлтэй байсан эсхийг тодорхойлно.

4.2 Зөвлөмжүүд боловсруулах: Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал, ил тод байдлын системийг сайжруулах талаар хэрэгжихүйц зөвлөмжүүдийг санал болгож Ажлын хэсэгтэй тохиролцоно.

Үе шат 5: ОҮИТБС-ын тайлагналын үр өгөөж

Зорилт: ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн зорилго нь Ажлын хэсгээс дэвшүүлсэн зорилтуудын эрэмбэ, тухайн улсын нөхцөл байдалд нийцүүлэн олборлох салбарын засаглалын асуудлаар болох олон нийтийн хэлэлцүүлэгт мэдээлэл өгөх юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд ОҮИТБС-ын тайлан нь ойлгомжтой, хүртээмжтэй байх бөгөөд гол оролцогч талууд, мэдээллийн хүртээмжтэй холбогдсон бэрхшээл, олон төрлийн бүлгүүдийн мэдээллийн хэрэгцээг тооцон, түүнд аль болох нийцсэн байна. Тайлангуудыг боловсруулахдаа түүний хэмжээ, хэлийг сайтар тооцож боловсруулах ба гол дүгнэлтүүдийн хураангуйг хавсаргасан байна.

ОҮИТБС-ын нэгтгэл тайлан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- **Танилцуулга:** Энэ хэсэгт тайлант хугацааны зорилт, зорилтуудын эрэмбийг Ажлын хэсэгтэй зөвлөлдөн оруулсан байна. Энэ хэсэгт засаглалын гол асуудлуудыг томьёолж, тайлангийн зорилго нь макро эдийн засгийн үзүүлэлтүүд, олборлох салбарын засаглалын өрнөж байгаа, эсхүл төлөвлөж байгаа шинэчлэл, төсвийн санхүүгийн удирдлага, олборлох салбартай холбогдсон хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд нөхцөл бололцоо бий болгосон эсхийг танилцуулна.

- **Олж авсан ажиглалт ба зөвлөмжүүд:** Энэ хэсэгт засаглалын гол асуудлуудын хэрхэн шийдвэрлэх талаар мэдээлэл орсон байна. Үүнд:
  - Ямар сувгаар мэдээлэл ил тод болгосныг тодорхой үзүүлнэ.(системтэйгээр ил тод болсон, эсхүл нэгтгэл тайлангаар ил тод болсон эсэх);
  - Хүчин төгөлдөр норм, журмаас гажсан зөрүүний танилцуулга;
  - Засгийн газар, компанийн нийтэд ил тод болгох системийг сайжруулах талаар хэрэгжихүйц зөвлөмжүүд;
  - Явагдаж байгаа болон санал болгосон олборлох салбарын засаглалтай холбоотой хууль, журам, захиргааны баримт бичгүүдийг шинэчлэх тодорхой зөвлөмжүүд;
  - Үндэсний хэмжээний асуудлууд, тухайлбал, авилгатай тэмцэх, дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний шилжилтийг хэрэгжүүлэх зэрэг асуудлаар явуулах бодлогын хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг энэхүү тайлан нь хэрхэн дэмжиж байгаа тухай энэ хэсэгт байна.
- **Олборлох үйлдвэрлэлийн нэмүү өртөгийн салаа бүрт ил тод байдлын нөхцөл байдал:** Энэ хэсэг нь ОҮИТБС-ын стандартын дагуу ил тод болж буй агуулга болон Ажлын хэсгээс тодорхойлсон цар хүрээнд ид тод болсон агуулгыг хамрана. Олборлох үйлдвэрлэлийн нэмүү өртөгийн салаа бүрээр эсхүл сэдэвчилэн бүлэглэх байдлаар мэдээллийг танилцуулна. (өөрөөр хэлбэл, төрийн өмчийн ил тод байдал гэсэн бүлэг байх жишээтэй).

ОҮИТБС-ын тайланг хэвлэн нийтлүүлэхээс өмнө Үндэсний зөвлөлөөс баталсан байх ёстой. Ажлын хэсэг нь тайлангийн эцсийн хувилбарыг хянасан байна. Хэрэв оролцогч талууд нэмэлт санал, нэмэлт зүйл оруулах бол зохиогчийн эрхийг тодорхой зохицуулсан байна.

<u>Хуулийн этгээд</u> нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

5.1 **Орчуулгын ажлыг хийсэн байна:** Эцсийн тайланг англи хэлрүү орчуулсан байна.

5.2 **Өгөгдлийн хураангуйг боловсруулж, ОУНБГ-т хүргүүлнэ:** 2024 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн өгөдлийн хураангуй "Data summary"- ыг ОҮИТБС-ын ОУНБГ-аас баталсан маягтуудын дагуу боловсруулж, тайлангийн эцсийн хувилбарын хамт хэвлэн нийтлүүлэх арга хэмжээ авна. Үндэсний зөвлөлөөр батлуулсны дараа **<u>Хуулийн этгээд</u>** нь ОУНБГ-т холбогдох хүснэгт, маягтын дагуу цахимаар хүргүүлнэ.

5.3 **Тайлангийн хүртээмжийг хангана:** Тайланг иж бүрэн, тодорхой, уншигдахуйц, хэрэглэгдэхүйц байлгана. Ажлын хэсгээс мэргэжлийн найруулга, загварыг сайжруулж, тайланг тодорхой, үзэмжтэй байлгахыг хүсч болно.

Анхаарах: Эдгээр ажлыг хэрэгжүүлэхдээ Ажлын хэсэг нь 3 дагч талаар аутсорс үйлчилгээ авч болохыг зөвшөөрөхөөс гадна зохих чиглэлийг өгсөн байна.

5.4 **Цуглуулсан материалуудаа Ажлын албанд хүлээлгэн өгнө:** Тулган баталгаажуулалтын явцад тайланд хамрагдсан байгууллагуудын тухай хуримтлуулсан бүх өгөгдлийг холбоо барих мэдээллийн хамт Ажлын албанд хүлээлгэн өгнө.

Анхаарах: Энэ зааврыг хэрэв **<u>Хуулийн этгээд</u>** бүх өгөгдөл мэдээллээ Ажлын албанд хүлээлгэн өгөх бол хэвээр хадгална. Хэрэв өгөгдөл мэдээллийг 3-дагч этгээд буюу Засгийн газрын харьяаны их сургууль зэрэг байгууллага байх тохиолдолд энэ зааврыг хасна.

5. **ОҮИТБС-ын нэгтгэл тайлан боловсруулах <u>Хуулийн этгээд</u>-эд тавих мэргэжлийн шаардлага**

<u>Хуулийн этгээд</u> нь компаниудын төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогыг нэгтгэхдээ заавал олон улсын мэргэжлийн стандартуудыг ашиглана(шаардлага 4.9). Тендерт оролцогсод нэгтгэх/тайлан гаргахад ашиглах процедуртаа зохих мэргэжлийн стандартуудыг заавал баримтлан ажиллана (мөн түүнийг хэрхэн баримтлахаа харуулна).

<u>Хуулийн этгээд</u> нь аудит эсхүл зөвлөх үйлчилгээний компани, эсхүл түүнтэй адил төстэй үйлчилгээ үзүүлэгч байх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Аудит эсхүл зөвлөх үйлчилгээний компани, эсхүл түүнтэй адил төстэй үйлчилгээ үзүүлэгч нь ямар чиг үүрэгтэй, ямар оролцоотой байхыг тусгаж, Монгол Улсад зохион байгуулагдах уулзалт, сургалт, ОҮИТБС-ын Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөлийн хуралд заавал биечлэн оролцох үүрэг хүлээсэн байх.
- Аудит эсхүл зөвлөх үйлчилгээний компани, эсхүл түүнтэй адил төстэй үйлчилгээ үзүүлэгч нь Монгол улсын олборлох салбар, төсвийн орлого, татвар, төлбөр, гаальтай холбоотой хууль эрх зүйн орчны өндөр мэдлэгтэй, тайлан гаргах, дүгнэлт гаргуулах, аудит хийлгэх асуудлаар Засгийн газар, агентлаг, эрх бүхий байгууллагаас гарган мөрдүүлж байгаа журам, заавар, маягт, тайлан, бусад мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна.
- Аудит эсхүл зөвлөх үйлчилгээний компани, эсхүл түүнтэй адил төстэй үйлчилгээ үзүүлэгч нь мэргэжлээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн болох нь нотлогдсон байх;
- Компани нь шаардлага хангасан ажилтнуудтай байх хийгээд үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чадавхтай байна;
- ОҮИТБС-ын мэдлэгтэй, энэ чиглэлээр өмнө нь тайлангийн нэгтгэл болон баталгаажуулалт хийж байсан туршлагатай байх нь давуу тал ч, заавал шаардахгүй;
- Аудит эсхүл зөвлөх үйлчилгээний компани, эсхүл түүнтэй адил төстэй үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйлчилгээг явуулах хүчинтэй тусгай зөвшөөрлийн хуулбарыг хавсралтаар заавал ирүүлнэ;
- Хэрэв түншлэлийн хэлбэрээр оролцох бол түншлэл байгуулсан тухай нотлох баримтыг сонирхлоо илэрхийлэхдээ хуулбарыг нь заавал ирүүлнэ. Хэрэв өөрийн салбар, эсхүл охин компанитай хамтран гүйцэтгэх бол хамтран хэрэгжүүлэх тухай нотолгоог заавал ирүүлнэ;
- Энэхүү ажлыг чанартай, хараат бус байдлаар явуулах үүднээс **<u>Хуулийн этгээд</u>** нь тендерийн саналдаа бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчил, түүнээс яаж зайлсхийх боломжтой талаарх мэдээллийн хамт тусгах шаардлагатай. Үүнд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг геологи, газрын тос, уул уурхай, хүнд үйлдвэрийн компаниудын санхүүгийн нэгдсэн тайланд сүүлийн 3 жил аудит хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бол ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзэх бөгөөд хэрэв сонгогдож энэ ажлыг хийхээр болбол хэрхэн хараат бус ажиллах талаар холбогдох тайлбар, танилцуулгыг заавал ирүүлнэ.
- Гурваас доошгүй жилийн өмнөх хугацаанд ажил үйлчилгээний чиглэлээрээ бүх шатны шүүхийн болон бусад гомдол, маргаанд оролцоогүй байгаа тухайгаа нотолгооны хамт заавал ирүүлнэ. Оролцсон бол татгалзах үндэслэл болно.

6. Тайлан боловсруулах шаардлага, гарах бүтээгдэхүүний хугацаанууд

ОҮИТБС-ын тайлагналын энэхүү ажлыг 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдөр эхэлж, нэгтгэл тайлангийн эцсийн хувилбарыг 2025 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр батлуулсан байна гэсэн тооцоололтой байна.

Хавсралт А Суурь мэдээллүүдийн баримт бичгүүд:

Олборлох үйлдвэрлэлийн засаглал, татварын бодлоготой холбогдсон хууль болон журмууд, холбогдох баримт бичгүүд:

- [...]
- [...]

ОҮИТБС-ын ажлын төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичгүүд:

- [...]
- [...]

Хамрах хүрээний урьдчилсан судалгааны дүгнэлтүүд:

- [...]

ОҮИТБС-ын өмнөх нэгтгэл тайлангууд:

- [...]
- [...]

ОҮИТБС-ын өмнөх нэгтгэл тайлангуудад өгсөн саналууд:

- [...]
- [...]

Баталгаажуулалтын тайлангууд:

- [...]
- [...]

Холбогдох бусад баримт бичгүүд(тух. Жилийн ажлын тайлан):

- [...]
- [...]

<u>Хуулийн этгээд</u> нь ОҮИТБС-ын тайланд хамрагдах дараах төлбөр, орлогын материаллаг байдлын талаар тооцоог гаргаж Ажлын хэсгээс санал авсан байна. Үүнд:

- Материаллаг байдал болон босгын тодорхойлолт, мөн үүнээс үүдэн

шаардлага 4.1(c)-ийн дагуу хамрагдах орлогын урсгалууд;

- Шаардлага 4.2-ын дагуу үйлдвэрлэлээс төрд ногдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого;
- Шаардлага 4.3-ын дагуу дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцоо;
- Шаардлага 4.4-ийн дагуу тээврийн орлого;
- Шаардлага 4.5-ын дагуу төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хийсэн эсвэл хүлээн авсан төлбөрийн нэгтгэл, тайлагнал;
- Шаардлага 4.6-ын дагуу материаллаг байдал болон орон нутагт хийгдэж буй шууд төлбөр;
- Шаардлага 5.2-ын дагуу материаллаг байдал болон орон нутаг дахь шилжүүлэг;
- Шаардлага 4.7-ийн дагуу ОҮИТБС-ын тайлангийн орлогын задаргааны түвшин ба төрлүүд;
- Шаардлага 6.1-ийн дагуу нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалт;
- Шаардлага 4.1(c)-ийн дагуу улсад материаллаг төлбөр төлсөн, тайлагнах үүрэгтэй компаниуд болон төрийн өмчит компаниуд;
- Шаардлага 4.1(c-d), 4.5 болон 4.6-ийн дагуу материаллаг төлбөр хүлээн авдаг, тайлагнах үүрэгтэй төвийн болон орон нутгийн төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд;
- Материаллаг байдлын босгонд хүрэхгүй байгаа орлого гэх мэт төлбөрийн урсгал бүрээр хүлээн авсан орлогын нийт дүнг нэг бүрээр нь ОҮИТБС-ын хамрах хүрээний дагуу бүрэн тайлагнахад засгийн газарт тулгарч буй бэрхшээлүүдийг олж тогтоох (шаардлага 4.1(d)).
- ОТАХ-ийн зөвшилцсөн бусад мэдээллүүд. (Тух."Төсөл" гэдэгт юуг авч үзэх тухай тодорхойлолт, төслийн түвшинд тайлагнах орлогын урсгалуудын тойм болон санхүүгийн мэдээлэл);

Хүснэгт 1 – ОҮИТБС-ын тайланд нэгтгэн оруулан ил од болгох мэдээллүүд, тэдгээрийг цуглуулан авах эх сурвалжууд

ОҮИТБС-ын тайланд оруулах буюу ил тод болгох мэдээллүүд[9]	**Хуулийн этгээд нь дараах мэдээллийг нэр дурдсан байгууллагуудаас хүлээн авч, тайландаа оруулна.**

[9]Энэ мэдээллийг гаргахдаа хураангуй өгөгдлийн маягтыг ашиглах бөгөөд ОҮИТБС-ын стандарт (2-р хэсэг) -т бичигдсэн орлогын бус мэдээллийн олон нийтэд зориулсан бөглөх маягтын жагсаалт, (3-р хэсэг)- т бичигдсэн тайлагнах компаниудын жагсаалт, болон (4, 5-р хэсэг)- т бичигдсэн Засгийн газар, компани, төслийн орлогын өгөгдлийг тоймлоход туслах хүснэгтийг ашиглана.

Олборлох салбарын эрх зүйн тогтолцоо, төсвийн бодлогын талаарх тодорхой мэдээлэл ОҮИТБС-ын шаардлага 2.1	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АҮЭБЯ, СЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Тусгай зөвшөөрөл олголтын журам, хуваарилах практикийн талаарх мэдээлэл ОҮИТБС-ын шаардлага 2.2[10]	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - 2024 онд шинээр олгосон, эсхүл шилжүүлсэн тусгай зөвшөөрлийг; - Тусгай зөвшөөрөл олгох, эсхүл гэрээ байгуулахыг саатсан, эсхүл хойшлуулсаныг; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл ОҮИТБС-ын шаардлага 2.3.[11]	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Гэрээний мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 2.4 [12]	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АҮЭБЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Тусгай зөвшөөрөл, гэрээнд оруулсан өөрчлөлт, нэмэлт, гэрээний хавсралт, шинэчилсэн хуваарь; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Эцсийн өмчлөгчийн тухай мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 2.5 [13]	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг Компаниудын гаргасан тайлангуудаас авч нэгтгэнэ.
Олборлох салбар дахь төрийн оролцооны мэдээлэл, төрийн өмчийн компанид төлсөн, эсхүл тэднээс хүлээн авсан төлбөрийн мэдээлэл, төсвийн шинжтэй зарцуулалт байгаа эсэх, ОҮИТБС-ын шаардлага 2.6, 4.5 болон 6.2.[14]	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг Эрдэнэс Монгол ХХК-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - ТӨК-ийн төрийн оролцоо, бодлогын өөрчлөлтүүд; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;

[10] Анхааруулах Зааварчилгаа 4: Лиценз олголт, https://eiti.org/files/Guidance%20note%204%20-%20License%20Allocations_FINAL_20131113.pdf

[11] Анхааруулах зааварчилгаа № 3: Тусгай зөвшөөрлийн бүртгэл, https://eiti.org/guide/license-registers

[12] Анхааруулах зааварчилгаа №7 Гэрээний ил тод байдал https://eiti.org/guide/contracts

[13] Эцсийн эзэмшигчийн мэдээлэл, мэдүүлэг, https://eiti.org/document/tools-to-include-beneficial-ownership-information-in-eiti-reporting

[14] Анхааруулах зааварчилгаа №18: ОҮИТБС-ын тайланд ТӨК оролцох нь, https://eiti.org/GN18

Олборлох салбарын талаарх товч танилцуулга, үүнд хайгуулын томоохон үйл ажиллагааны талаарх мэдээлэл орно ОҮИТБС-ын шаардлага 3.1	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Үйлдвэрлэл, экспортын мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 3.2 болон 3.3.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт; - 2024 оны үйлдвэрлэл, экспортыг компани, төслөөр нь задлан харуулах.
Олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан татвар, орлогыг иж бүрнээр нэг талаас ил тод болгох, төсөл бүрээр задлах, ОҮИТБС-ын шаардлага 4.1 болон 4.7.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг ТЕГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Олборлох үйлдвэрлэлээс 2024 онд төлөвлөсөн, бодитоор хүлээн авсан орлого; - Санхүүгийн дэглэмд дэмжлэг үзүүлсэн эсхүл олборлох үйлдвэрлэлд үзүүлэхээр тооцсон ирээдүйн орлогын тооцооллын танилцуулга; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрд ногдох хэсгийг худалдан олсон орлого, мөн буцалтгүй хэлбэрээр хүлээн авсан бусад орлогын мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 4.2.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ, Эрдэнэс Монгол ХХК-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрд ногдох хэсгийг худалдан олсон болон буцалтгүй хэлбэрээр хүлээн авсан бусад орлого; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Дэд бүтэц, бартерийн зохицуулалтын талаархи мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 4.3.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг Компаниудын гаргасан тайлангуудаас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт; - Шинэ, эсхүл шинэчилэгдсэн байгалийн баялагаар барьцаалсан зээлийн хэлэлцээр
Тээвэрлэлтийн орлогын мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 4.4.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг ЗТХЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт; - 2024 онд хийгдсэн нүүрсний тээврийн шинэчлэлийн тухай мэдээллийг;

Орон нутгийн шууд төлбөрийн мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 4.6.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг СЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Төлөвлөсөн болон бодит орон нутгийн төлбөр, орон нутгийн төсөвт үүссэн ямар нэг бэрхшээл; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан орлогын хуваарилалтын мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 5.1.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг СЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Олборлох салбараас хүлээн авах орлогыг тодотгол; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Орон нутгийн шилжүүлгийн мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 5.2.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг СЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Төлөвлөсөн болон бодит орон нутгийн шилжүүлэг, орон нутгийн төсөвт болон нутгийн иргэдэд үүссэн ямар нэг бэрхшээл; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Орлогын удирдлага, зардлын талаар ОТАХ-ээс хүсэлт болгосон бусад мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 5.3.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг СЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Орлого, төсвийн тооцооллын тодотгол (ашигт малтмалын үнийн таамаглалыг оруулна) - Авралын санхүүжилт, идэвхжүүлэх багц, олборлох салбарт, эсхүл төрийн өмчит компанид үзүүлсэн татаас; - Олборлох салбарын зээллэгийн өөрчлөлт; - Ирээдүйн өв сангийн хөрөнгийг онцгой нөхцөлд ашигласан эсхийг;
Нийгмийн зарцуулалт, байгаль орчны төлбөрийн мэдээлэл ОҮИТБС-ын шаардлага 6.1.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг ГБХНХЯ болон компаниудаас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмэж хамруулна. Үүнд: - Компаниудын нийгмийн зарцуулалтын төлөвлөгөөний өөрчлөлт, нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн үзүүлсэн байж болзошгүй үр нөлөө; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;
Олборлох салбараас улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр, ОҮИТБС-ын шаардлага 6.3.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг АМГТГ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Ашигт малтмалын үнэ нэмэгдсэн эсхүл бууснаас олборлох үйлдвэрлэлд болон эдийн засгийн нийт нөхцөл байдалд үзүүлсэн үр нөлөө; - Энэ шаардлагыг хангахад 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжөөр өгсөн саналын хэрэгжилт;

Олборлох үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлж буй нөлөөний мэдээлэл, ОҮИТБС-ын шаардлага 6.4.	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг БОЦУӨЯ-аас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Байгаль орчныг хамгаалах, цаг уурын өөрчлөлтийг бууруулах чиглэлийн хууль тогтоомжийн өөрчлөлт, чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвлөлдөөн хийгдсэн байгаа эсхийг;
Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас бүх төрийн байгууллагуудад олгосон хандив, дэмжлэгийн дэлгэрэнгүй мэдээлэл	Энэ шаардлагын дагуу холбогдох мэдээллийг компаниудаас авч нэгтгэхийн хамт дараах зүйлийг нэмж хамруулна. Үүнд: - Тулган баталгаажуулалтын үр дүнд үүсч болзошгүй зөрүүний талаар холбогдох талуудаас тайлбар авч, нэгтгэл тайланд хавсаргана; - Энэхүү мэдээллийг хүлээн авсан аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн болон төрийн бус байгууллагуудаар нь.
Монгол Улсын 2018-2022 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт	Монгол Улсын 2018-2022 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тухай мэдээлэл, биелэлтийг хангах талаар ажилласан тухай танилцуулга
Монгол Улсын 2022 оны ОҮИТБС-ын Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт	Монгол Улсын 2022 оны ОҮИТБС-ын Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тухай мэдээлэл, биелэлтийг хангах талаар ажилласан тухай танилцуулга
2023 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн өгөдлийн хураангуй -Data summary	ОҮИТБС-ын ОУНБГ- аас баталсан маягтын дагуу "Өгөдлийн хураангуй"- г боловсруулж цахимаар ОҮИТБС-ын ОУНБГ-т хүргүүлнэ.
Хүлэмжийн хийн ялгаруулалт 3.4-р шаардлага	Энэ шаардлагын дагуу Оюу толгой ХХК-ийн холбогдох мэдээллийг нэгтгэнэ.
Төслийн зардал 4.10-р шаардлага	Энэ шаардлагын дагуу Оюу толгой, Бадрах Энержи ХХК-ийн холбогдох мэдээллийг нэгтгэнэ.

Хянасан: АҮЭБЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга — Э.Батболд

Боловсруулсан: ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч — Ш.Цолмон

[1] https://www.parliament.mn/nn/30674/ Улсын төсвийн тэцвэржүүлсэн орлого 17,1 их наяд төг.